



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

2023 оны 02 дугаар сарын 10

№ 06/12

Улаанбаатар хот

「ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ」
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА ТАНАА

Комисс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11, 25.1.6, 29.6.4 дэх заалтад тус тус заасан чиг үүргийн хүрээнд Хорих ангид ял эдэлж буй хоригдлуудын Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөний хэрэгжилт, хүний эрхийн үндсэн зарчимд хэрхэн нийцэж буйг газар дээр нь шалгаж илэрсэн зөрчлийг таслан зогсоох, зөрчигдсэн эрхийг арилгуулах, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтын ажлыг 2022 оны 1, 2, 4 дүгээр улиралд зохион байгуулсан.

Хяналт шалгалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 405, 407, 409, 421, 423, 435, 445, 457 дугаар хорих ангиуд, аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байрыг хамруулан хийсэн бөгөөд судалгаанд 1142 хоригдол, 100 орчим алба хаагчийг түүвэрлэн оролцуулсан. Хяналт шалгалтын үр дүн, зөвлөмжийн биелэлтийг 2023 оны УИХ-ын хаврын чуулганд өргөн барьж Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлд тусгаж, хэлэлцүүлэх болно.

Комисс хорих ангийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тус газрын албан хаагчид болон хоригдлуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, удирдлага, холбогдох албан тушаалтнаас тайлбар авах, холбогдох бичиг баримт бичигт дүн шинжилгээ хийх аргачлалаар шалгалтыг явуулсан бөгөөд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

Нэг. Хорих анги, цагдан хорих төвийн ахуй нөхцөлийн талаар

Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2012 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 07-208/638 дугаар дүгнэлтээр Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын барилга нь зураг төсөлгүй, аж ахуйн аргаар баригдсан бөгөөд барилгын хананд цууралт үүссэн, хучлагаар борооны ус нэвчдэг, агааржуулалтын систем байхгүй, барилгын модон хийц үжирч муудсан Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтыг зөрчсөн гэж, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 02-07-383/64 дугаартай актаар тус байгууллагыг цаашид тус барилга дотор үйл ажиллагаа явуулахгүй байх шийдвэрийг тус тус гаргасан байна.

405 дугаар хаалттай хорих ангийн хорих ял эдлүүлэх байр 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар хүрэлцээтэй, нэг хоригдолд ногдох талбайн хэмжээ, гэрэлтүүлэг хэвийн байгаа ч барилгын чанар хуучирч муудсан, хорих өрөөний бие засах байгууламж тусгаарлах хэсэггүй, бохир зайлуулах усны систем, нүүр гар угаах хэсэгтэй, нэг шугамаар холбогдсон байдалтай, 435 дугаар хаалттай хорих анги, 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн хоригдлын байр, гал тогооны болон бусад барилга

байгууламж нь хуучирч муудсан, засвар үйлчилгээ авахад хүндрэлтэй, хүйтэн, байгалийн болон ерөөний гэрэлтүүлэг, агаар сэлгэлт муу, ундны цэвэр ус зөөврөөр авдаг, гадна бие засах газартай, стандартын бус эрүүл ахуйн шаардлага хангахгүй барилга байгууламжид үйл ажиллагаа явуулж байгаа, 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги төвийн халаалтын системд холбогдоогүй байна. Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байрны барилга нь 1956 онд эмнэлгийн төрөх тасгийн зориулалтаар баригдсан, барилга нь чулуун суурьтай, 1 метрийн өргөнтэй чулуун ханатай, хамар хана түүхий цагаан тоосго, хучилт мод, модон бамбай бүхий хийцлэлтэй бөгөөд 2002 оноос хойш тус барилгад их засвар хийж үйл ажиллагаа явуулж байх ба зуны улиралд дээврээс борооны ус нэвтэрснээс чийгтэй, хүйтэн нөхцөл байдал үүссэн бөгөөд үйл ажиллагаа явуулах боломжгүй байна. 405 дугаар хаалттай хорих анги, 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн гадна хамгаалалтын хашаа стандарт шаардлагад нийцээгүй, нурах эрсдэлтэй байлаа.

Хорих ангийн орчин нөхцөл, ерөөний тохижилтын талаар судалгаанд оролцсон 1141 хоригдлын 51.7 хувь нь сайн, 29 хувь нь дунд, 8 хувь нь муу, 11 хувь нь хариулахаас татгалзсан байна. Энэ судалгааны үр дүн зарим ангиудын хувьд илүү анхаарал татсан байдалтай гарч байгаа нь дээр дурдсан нөхцөл байдалтай шууд холбоотой гэж дүгнэж болно. Тухайлбал, хорих 435 хаалттай ангийн хоригдлуудын 72,3 хувь нь хорих ангийн орчин, нөхцөл, ерөөний тохижилтыг дунд болон муу гэж хариулсан байна.

Хоёр. Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх эрх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа зарим хууль тогтоомж, холбогдох журам, заавар, алба хаагчдын харилцаа хандлага хоригдолтой хүнлэг бус харьцаж, нэр төрийг нь доромжлон шийтгэх хэлбэрийг агуулж байгаа нь ажиглагдсан.

Шалгалтын явцад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчтай холбоотой хэд хэдэн ноцтой зөрчлийн мэдээлэл Комисст ирсэн бөгөөд одоогоор холбогдох байгууллагуудад шалгалтын ажиллагаа явуулж байна. Үүнд: Сэлэнгэ аймгийн Цагдан хорих төвд хоригдож байсан _____ нар 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр харуул хамгаалалтын ажилтан, дэд ахлагч _____ зодуулсан, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь хорих 413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлж байгаа хоригдол _____ нь харуул хамгаалалтын ажилтан _____ зодуулсан, _____ аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тасгийн дарга бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч _____ төлбөр төлөгч _____ 2020 оны 6 дугаар сараас хойш удаа дараа хэл амаар доромжилж, нэр төрийг нь гутаан доромжилсон, улмаар 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр албан ерөөндөө зодож эрх чөлөөнд нь халдсан, 405 дугаар хаалттай хорих ангийн Тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдол _____ Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь 435 дугаар хаалттай хорих ангид ял эдэлж байхдаа алба хаагчдын хүнлэг бус харьцаанд удаа дараа өртөж, ялгаварлан гадуурхагдаж, эрүүл мэндээрээ хохирсон талаар гомдлыг тус тус гаргажээ.

Хоригдлуудаас авсан санал асуулгын дүнгээр хорих ангийн ажилтан, алба хаагчид хоригдолтой хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэх явдалд өртөж байсан гэж 22.5 хувь, бусад хоригдол тийм байдалд орж байсныг харсан гэж 30.2 хувь нь тус тус хариулсан бол ярилцлагад оролцсон хоригдлууд алба хаагчдын зүй бус харьцаа, ялгаварлан гадуурхах, хууль тогтоомжийг өөрийнхөөрөө тайлбарлаж хоригдолтой зүй бусаар харьцах, дарамт үзүүлэх тохиолдол түгээмэл байдаг гэжээ. Түүнчлэн Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжигч "...бид хүний хөл угааж бариа хиймээргүй байна" гэж санал асуулгын хуудаст тусгайлан тэмдэглэсэн нь анхаарал татаж байлаа.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд албан хаагчид хоригдол, төлбөр төлөгчтэй хүнлэг бус харьцаж, нэр төрийг нь гутаан доромжлох явдал хорих ангиудад нийтлэг байж болзошгүй байна.

Нэгдсэн Үндэстний байгууллагаас баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”-ийн 47.3-т хорих ангийн алба хаагч нь ажилд орсны дараа болон цаашдын бүх үйл ажиллагааны явцад ажлаасаа хөндийрөхгүйгээр, зохих хугацаанд зохион байгуулагдан бэлтгэл сургалтад хамрагдан мэргэжлийн түвшингээ зохих түвшинд дээшлүүлж байх ёстой гэж заажээ.

Хорих ангид хоригдлыг сахилгын байранд 30 хүртэл хоногоор хатуу дэглэмд ганцаарчлан хорих шийтгэл оногдуулж байгаа нь хүнлэг бус хэрцгий шинжийг агуулж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хамтарсан А/236/, А/104 тоот тушаалаар баталсан “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл журам”-ын 5.1-д сахилгын байранд байгаа хоригдолд Хорих ангийн харуул хамгаалалтын журмын 7.8.4-т заасны дагуу өдөрт 2 удаа тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол олгоно”, мөн зүйлийн 2-т “сахилгын байранд байгаа хоригдлын хоолны илчлэг өдөрт 1000 кл клори байна”, тус журмын 2.1.3-т “180х60 см хэмжээтэй орыг хананд бэхэлсэн байх”, 7.6-д “Сахилгын байрны орыг 06.00-22.00 цагт дээш нь бэхлэж хураана” гэж тус тус заажээ.

Хяналт шалгалт хийсэн 7 хорих анги бүгд сахилгын байртай байсан ба тус ангиудад 2021-2022 оны эхний 10 сарын байдлаар 28 хоригдолд 30 хүртэл хоногоор сахилгын байранд хорих шийтгэлийг хорих ангийн даргын шийдвэрээр ногдуулжээ. Хяналт шалгалтын явцад сахилгын байранд шийтгэл эдэлж байгаа нэг хоригдолтой ярилцлага хийхэд “... Сахилгын байранд орсон хүн их юм ойлгоод гарах шинжтэй. Зүгээр хүн тамлаж байна. Өдөржин зогсоогоороо, ном уншихгүй, үзэх зүйл байхгүй, суух сандалгүй, хоол гэж идэхэд хүндрэлтэй зүйл байдаг. Жин хассан, өдөрт цагийн хуваарийн дагуу бие засаж байгаа...” гэж дурджээ.

Хоригдлыг сахилгын байранд хорих шийтгэлийн зорилго нь хорих ангийн дотоод журмыг ноцтой зөрчсөн хоригдлыг хуульд заасан хугацаанд сахилгын байранд ганцаарчлан хорьж, бусдаас тусгаарлах замаар өдөр тутмын цагийн хуваарьт арга хэмжээнд оруулахгүй байх, гаргасан зөрчил, дутагдлыг өөрт нь ойлгуулах, эерэг зан үйл төлөвшүүлэхэд чиглэгдэх ёстой бөгөөд үүнээс хэтэрч болохгүй. Гэвч холбогдох хууль, журмаар сахилгын байранд шийтгэл эдлэх нөхцөл, дэглэм нь бие махбодь, сэтгэл санааны шаналал, зовиурт өртүүлэх, хүнлэг бус шинжийг агуулж байна. Нөгөө талаар шүүхээр гэм буруутай нь тогтоогдож, хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын эрх чөлөөг хорих байгууллагын даргын шийдвэрээр дахин хязгаарлаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг зөрчсөн шинжтэй байна.

Бүх насаар хорих ял эдлүүлэх Тусгай нэгжид сахилгын зөрчил удаа дараа гаргасан үндэслэлээр бусад хорих ангиас зэрэглэл дээшлэн ирсэн 14 хоригдол ял эдэлж байгаа нь тэдний эрх зүйн байдлыг дордуулсан, хүнлэг бус хэрцгий харьцаа гэж дүгнэхээр байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 199 дүгээр зүйлд “хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна. Тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна”. Мөн хуулийн 206 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “Хоригдол 1 жилийн хугацаанд хоёр, түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан, эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан тохиолдолд зөвлөл нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлээс тусгай зэрэглэлд, хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлээс тусгай зэрэглэлд, тусгай зэрэглэлээс тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлэн шилжүүлэх саналаа прокурорт гаргаж, прокурор 10 хоногийн дотор шийдвэрлэнэ” гэж заажээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүнийг алах, хүчиндэх, төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах, олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст халдан довтлох зэрэг гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих ял оногдуулж болохоор заасан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд уг ялыг ганцаарчлан эдлүүлэх талаар хуульчилжээ. Хорих 405 дугаар ангийн Тусгай нэгжид зэрэглэл дээшлэн ял эдэлж байгаа

14 хоригдол ихэвчлэн удаа дараа хүнд гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдож байгаа ч хулгайлах, дээрэмдэх зэрэг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэж 2-7 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн ялтан тус нэгжид ял эдэлж байгаа нь хүний эрхийн ноцтой зөрчил, дур зоргын шинжтэй хүний эрхийн хязгаарлалт юм.

Тусгай нэгжид зэрэглэл дээшлэн ял эдэлж байгаа хоригдолтой ярилцахад "...Хаалттай хорих ангид ял эдэлж байхдаа өргөдөл гомдол гаргах, бодит зүйлийг шүүмжлэх, санал хүсэлт тавих болон үл ялих зүйлээр шалтаглаж сахилгын шийтгэл ногдуулж, хувийн өс хонзонгийн сэдэлтээр зэрэглэл дээшлүүлэх санал гаргадаг, прокурор бодит байдлыг сайтар нягтлахгүй шийдвэр гаргадаг гэжээ.." гэж, мөн хорих ял эдлүүлэх хорих ангийн зэрэглэлийг хүндрүүлэн өөрчлөх тухай прокурорын шийдвэрт эдлээгүй үлдсэн бүх ялыг хаалттай дэглэмийн Тусгай нэгжид эдлүүлсүгэй гэж дурдаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1-т "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн зүйлийн 3 дахь хэсэгт "Эрүүгийн хариуцлага нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна." гэж заасантай нийцэхгүй байна.

Монгол Улсын Их хурлаас 2015 онд баталсан Эрүүгийн хуулийн ялын бодлогын шинэчлэлд хүнийг тусгайлсан дэглэм бүхий байранд ганцаарчлан хорьдог баривчлах ялыг халж, хорих ял эдлэх хугацаанд нийгэмшүүлэх, зан үйлд нөлөөлөх сургалтыг үр дүнтэй зохион байгуулах, суллагдсан хүнийг нийгэмд дасан зохицож амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үзэл баримтлалыг тусгасан.

405 дугаар хаалттай хорих анги (тусгай нэгж) бүх насаар хорих ялтай 19, бусад хорих ангиас зэрэглэл хүндрүүлэн ирсэн 14, нийт 33 хоригдол ял эдэлж байна. Тусгай нэгжид хорих ял эдэлж байгаа хоригдлуудыг халуун усанд орох, гадаалах, эргэлт уулзалт авах, хөндлөнгийн эрх бүхий байгууллага, албан тушаалтантай уулзалт ярилцлага хийхэд байнгын гар, хөлийн гавтай байлгаж, тэднийг хорих өрөөнөөс бусад газарт дагуулж явахдаа толгойг бөхийлгөж дарах зэрэг зүй бус хандлага ажиглагдсан. Тус ангид хоёр хоригдлын дунд нэг зурагт үзэх боломжтойгоор хананд байрлуулсан, "TV-405 нийгэмшүүлэх телевиз" шууд нэвтрүүлгийн өрөө байгуулсан, холбогдох сургалтын видео бичлэгүүдийг бэлтгэсэн, цэвэр усаар 2 цаг тутамд хангах боломж нөхцөлөөр хангасан зэрэг нь сайшаалтай байлаа. Харин зарим телевизийн дуу-дүрсний гаралт муу, хуучирч муудсан, ихэнх нь төрийн бус байгууллагаас хандив тусламжаар ирсэн, нийгэмшүүлэх телевизийн ажиллагаа бэлэн биш, үзүүлж байгаа бичлэг, сургалтын материалууд цаг үеэсээ хэт хоцорсон, хоригдлын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр бодлогын түвшинд анхаарч хөрөнгө оруулалт хийдэггүй, 1-7 жилийн хугацаанд хоригдлоор хөдөлмөр эрхлүүлээгүй, өрөөнд хоёр хоёроор нь байлгах холбогдох хуулийн зохицуулалтыг огт хэрэгжүүлэхгүй байгаа нь тэдгээр хоригдолтой хүнлэг бус харьцаж байгаа бодлого, үйл ажиллагаа юм.

Хорих ангиудад хоригдлын өрөөний гадна талд хоригдлын овог нэр, ял шийтгүүлсэн эрүүгийн хуулийн зүйл, ангийг агуулсан мэдээллийг байрлуулсан нь ялгаварлан гадуурхалтад өртөх, хүний нэр төрийг нь гутаан доромжлох эрсдэлийг нэмэгдүүлдэг байна. Хоригдлуудтай хийсэн ярилцлагад "... үйлдсэн гэмт хэргийн зүйл ангиар дуудаж, сэтгэл зүйн дарамтад байнга өртүүлдэг, үйлдсэн хэрэгтээ гэмшиж, мартаж ядаж байхад хүүхдээ хүчиндсэн гэх мэтээр байнга доромжилдог, энэ байдлаас болж бусадтай маргалдах, сахилгын зөрчил гаргах тохиолдол цөөнгүй гардаг гэжээ...", түүнчлэн хоригдлын нэрийг дуудахаар "эцгийн нэрээ" бүтнээр хэлдэг бичигдээгүй дэг жаяг үйлчилж байгаа нь хүний нэр төрийг гутаан доромжилсон шинжтэй, хүнлэг бус харьцаа бөгөөд хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг зөрчсөн үйлдэл гэж үзнэ. Ярилцлагад хамрагдсан хоригдлуудаас энэ хандлагыг өөрчилж өгөхийг хүссэн бөгөөд энэ талаар харуул хамгаалалтын ажилтнаас тодруулахад "...хорих ангиас оргох, бусад хүмүүсийн өмнөөс ял эдэлж байсан тохиолдол гарч байсантай холбоотойгоор урьдчилан сэргийлэх зорилгоор эцгийн нэрийг бүтнээр нь дуудуулдаг талаар тайлбарлаж байсан..." болно.

Дээрх үйлдлүүд нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-т "хүний хувийн мэдээлэл гэж ... хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр", мөн зүйлийн 4.1.12-т "хүний эмзэг мэдээлэл гэж ... ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх...мэдээллийг" ойлгоно, мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-т "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж, Монгол Улсын нэгдэн орсон эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгийн хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 16 дугаар зүйлд "Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ 1 дүгээр зүйлд тодорхойлсон эрүү шүүлтэд тооцогдохгүй төрийн албан тушаалтан буюу албаны үүрэг гүйцэтгэж буй бусад этгээд, тэдгээрийн едөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр үйлдэгдэх хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх бусад үйлдлээс сэргийлэх үүрэг хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд үр нөлөөгүй арга хэмжээ гэж дүгнэсэн.

Хорих анги, цагдан хорих байранд ихэвчлэн 2-4 хоригдол, хоригдогсод нэг өрөөнд байрлаж байна. Хоригдогсдын бие засах хэсгийг өрөөний дотор байрлуулсан, ямар нэгэн хаалт, тусгаарлалтгүй (эвдэрсэн), ил задгай, агааржуулалт муутай, нойлын үнэр үнэртсэн, биенийхээ дэргэд ээлжээр бие зассан байдалтай байсан бөгөөд энэ байдал камерын хяналтад бүрэн харагдаж байгаа нь хүний халдашгүй чөлөөтэй байх, хувийн нууцтай байх эрхийг хөндөж байна.

Гурав. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийн талаар

Хорих байгууллага бүр эмнэлэгтэй, шаардлагатай эм тарианы нөөцийг бүрдүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж хэвшсэнээс гадна, хоригдлуудыг тогтсон хугацаанд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, хүнд, нэн хүнд өвчтэй хоригдлыг шаардлагатай нарийн мэргэжлийн эмнэлэгт эмчилгээнд хамруулах арга хэмжээ авч байгаа нь сайшаалтай байна. Гэсэн хэдий ч хорих ангийн эмнэлэгт төсвөөс шалтгаалан эм, эмнэлгийн хэрэгслийн хүрэлцээ, хүртээмж муу байгаа нь хоригдлын эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх зөрчигдөх эрсдэлд хүргэж болзошгүй байдал тогтоогдсон. Ангийн эмчээс эм, тарианы хүрэлцээ, хүртээмжид төсөвлөгдсөн мөнгө хүрдэг эсэх талаар тодруулахад төсөвт мөнгийг байнга хэрэглэдэг өвчин намдаах, артерийн даралт бууруулах, хоол боловсруулах эрхтэнд уудаг эм, тариа болон яаралтай тусламжийн эм, тариаг авахад зарцуулдаг. Төсөв мөнгөний хүрэлцээ, хүртээмж дутмаг байдаг, өөрсдийн боломжоор л асуудлыг шийдвэрлэдэг гэх тайлбарыг өгч байсан нь анхаарал татсан.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын хувьд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг ариун цэврийн стандартын шаардлага хангахгүй өрөө, орчинд үзүүлж байна. Тодруулбал гар угаалтуур байхгүй, MNS 6655:2017 стандартын хавсралт "С"-д ЦАБЭМТ I-д үзлэгийн ор, ажиглалт тусгаарлалтын ор байх шаардлага тавьсан байх бөгөөд уг эмчийн өрөөнд нэг үзлэгийн ор байсан бөгөөд төнөг төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй байгаа нь санаа зовоож байна.

Санал асуулгад оролцсон 1142 хоригдлын 138 буюу 12 хувь нь эмнэлгийн тусламж цаг тухайд нь авч чаддаггүй, 60 буюу 5,2 хувь нь эмч эмнэлгийн тусламж үзүүлэхээс цааргалж харьцдаг, 91 буюу 7.9 хувь нь хариулт өгөхөөс татгалзсан байна. Харин судалгаанд оролцогчдын 754 буюу 66 хувь нь эмнэлгийн тусламжийг цаг тухайд нь авч чаддаг гэжээ. Хоригдлуудтай хийсэн ярилцлагад эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээл байхгүй, түргэн шуурхай байдаг гэж нийтлэг байдлаар хариулж байсан бол эм тариа хүрэлцээ муу мөнгө санхүүтэй холбоотой асуудал байдаг гэх хариултыг цөөнгүй хоригдол өгчээ.

Дөрөв. Нийгмийн ажил, сэтгэл зүйн үйлчилгээний талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны А/207 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Хорих ял эдлэх үеийн сургалтын жишиг хөтөлбөр”-ийг баталж, тус хөтөлбөрийг хэрэгжүүлж сургалтыг үр дүнтэй зохион байгуулахыг Хорих ял эдлүүлэх албаны 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 08/2386 дугаар албан бичгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа газар, хэлтэс бүх анги, байгууллагад хүргүүлсэн байна.

Шалгалтад хамрагдсан хорих ангиуд хоригдлын дунд явуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөөг ангийн даргаар батлуулж, нийгмийн ажилтан шинээр ирсэн хоригдолтой ажиллах, хорих ял эдэлж байгаа, суллагдах дөхсөн болон сахилгын зөрчил гаргасан хоригдлын зан байдлыг өөрчлөх, хөдөлмөрийн дадал олгох, нийгэмд дасан зохицож амьдрахад чиглэсэн сургалтыг танхим, видео, дугуйлан, ганцаарчлан зөвлөгөө өгөх хэлбэрээр зохион байгуулсан. Түүнчлэн шашны зан үйлийн өрөө, номын сан, сэтгэл зүйн болон сургалтын танхимуудыг байгуулж, цагийн хуваарийн дагуу ажиллуулж байгаагаас гадна хоригдлыг ар гэртэй нь уулзах нээлттэй хаалганы өдөрлөгийг жил бүр зохион байгуулж хэвшсэн, иргэний бүртгэлийн зөрчилтэй хоригдлыг бүртгэлжүүлж төрөөс олгох мөнгөн дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан зэрэг сайшаалтай ажлууд байгааг дурдах нь зүйтэй.

Гэсэн хэдий ч хоригдлуудтай хийсэн ярилцлага, санал асуулгын дүнгээр сургалт, нийгмийн ажлын чанар үр нөлөө, сургалтын орчинг сайжруулах талаар санал илэрхийлж байсныг анхаарах нь зүйтэй. Тухайлбал, магадланд орох боломжгүй хоригдлуудыг ямар нэг байдлаар шалтаг тоочин сургалтад хамруулдаггүй боловч сургалтад хамрагдсан хоригдлуудын тоонд оруулан тайланд тусгадаг, сахилгын зөрчил гаргасан тохиолдолд нийгэмшүүлэх хөтөлбөрт хамруулдаггүй, сургалтыг үр дүнтэй зохион байгуулдаггүй, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нар бодитой ажил хийдэггүй, видео хичээл нь цаг үеэсээ хэт хоцрогдсон гэж ярилцлагын явцад илэрхийлж байсан. Харин санал асуулгад оролцсон хоригдлуудаас “чөлөөлт цагаа хэрхэн өнгөрүүлдэг вэ?” гэж асуухад 56.6 хувь нь ном сонин уншдаг, 7.6 хувь нь тийм боломж байдаггүй, 12.8 хувь нь угаалга, хатаалгын өрөөнд өнгөрөөдөг, 6.7 хувь нь суралцдаг, 7.8 хувь нь зөвшөөрөгдсөн спортоор хичээллэдэг, 4.0 хувь нь шашин зан үйл үйлддэг гэж хариулсан бол 12 хувь нь ямар нэгэн хариулт өгөхөөс татгалзсан байна. Хорих ангийн тохижилт үйлчилгээ муу гэж 4 хорих ангийн нийт 92 хоригдол хариулснаас 15.2 хувь нь номын сан ашиглуулдаггүй, 68.4 хувь нь сургалтын өрөө танхим тохижилт муу гэжээ. Шалгалтын явцад хорих ангиудын төсөвт сургалт, нийгмийн ажил болон номын сангийн баяжилт, үйл ажиллагаанд зориулсан санхүүжилт хангалттай тусгагддаггүй, сургалтын хэрэглэгдэхүүнийг дотоод нөөц бололцоо, төрийн бус байгууллагын дэмжлэгээр хэрэгжүүлдэг тохиолдол цөөнгүй байна. Хоригдлын дунд бичиг үсэг үл мэдэгч цөөнгүй байсан бөгөөд ангиудын удирдлагын зүгээс “... тэдгээр хоригдлуудад бичиг үсгийн боловсрол олгох сургалтыг цахимаар болон танхимаар олгож байгаа” гэх тайлбарыг Комисст өгч байсан боловч бодит байдал дээр сургалтад хамрагдсан гэх хоригдлуудын дунд бичиг үсэг тайлагдсан нь цөөхөн байлаа. Түүнчлэн зарим хорих ангийн нийгэм, сэтгэл зүйн нэгжид нийгмийн ажилтны орон тоо дутуу ажиллаж байгаа нь үйл ажиллагаа доголдоход хүргэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “хорих ял эдлүүлэх үеийн сургалтын жишиг хөтөлбөр”-т тусгагдсан сургалт зохион явуулах, нийгмийн ажил, сэтгэл зүйн зүйн үйлчилгээ үзүүлэх ажил хорих анги бүрт харилцан адилгүй явагдаж байгаад дүгнэлт хийж, сайжруулах шаардлагатай.

Тав. Эргэлт, уулзалт авах, өргөдөл гомдол гаргах эрхийн талаар

Хорих ангиуд хоригдлын эргэлт, уулзалтыг хуульд заасан хугацаанд зохион байгуулж хэвшсэнээс гадна ар гэртэй нь уулзуулах нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, тэдний гаргасан санал хүсэлт, өргөдлийг тухай бүрт нь хүлээн авч, шийдвэрлэж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан удаан хугацааны уулзалтыг зохион

байгуулах байрны өрөө, түүний зохион байгуулалт харилцан адилгүй, дотоод нөөц бололцоогоор тохижуулсан шинжтэй байна. Ихэнх хорих ангийн уулзалтын байрны өрөө, тасалгааны тохижилт, гэрэлтүүлэг муу, тавилга хэрэгсэл хуучирч муудсан байдалтай байсан бөгөөд зохих хэмжээний төлбөртэй үйлчилдэг талаар дурдаж байв.

Ярилцлагад оролцсон зарим хоригдлуудаас өргөдөл, гомдол гаргах эрх нээлттэй ч шийдвэрлэлт хангалтгүй байдаг талаар мэдээлэл өгч байв. Мөн хөдөлмөр эрхлэхтэй холбоотой гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэдэггүй, хорих ангийн алба хаагч, үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хүлээн авдаггүй, авсан ч дотооддоо шийдвэрлэдэг, хүний эрхийн болон бусад байгууллагад уламжилж өгдөггүй гэж байсан нь анхаарал татаж байлаа.

Зургаа. Алба хаагчдын хөдөлмөрлөх эрх

Хорих 435, 405, 457, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, Баян-Өлгий аймаг дахь Цагдан хорих төвийн нөхцөл байдал, цэвэр бохир усны холболт, ариун цэврийн байгууламж, алба хаагчдын өрөө, хувцас солих тасалгаа, цайны газар бусад барилга хуучирч муудсан, засвар хийгдээгүй байдалтай байна. Улаанбаатар хот, аймгийн төвийн ойролцоох хорих ангиудад алба хаагч усанд орох, алжаалаа тайлах, зөвлөгөө авах, чанартай хоол хүнсээр хангагдах, тээврийн хэрэгсэл болон эрүүл мэндийн зардал, цалин хөлсний нэмэгдэл бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Ялангуяа, өөрийн үйлдвэр, үйл ажиллагааны тодорхой чиглэлгүй, хөрөнгө төвлөрүүлэх боломжгүй хаалттай хорих анги, тусгай нэгж, хүүхэд хүмүүжиж байгаа ангид ахуй нөхцөл эрс муу байгааг бодлогын түвшинд анхаарч ахуй нөхцөлийг сайжруулах шаардлагатай.

405 дугаар хаалттай хорих ангийн (тусгай нэгж) алба хаагчдын хөдөлмөрийн нөхцөлд ажиглалт хийхэд 5-7 цоожтой хаалганы цаана үүрэг гүйцэтгэж, сэтгэл зүйн хувьд таагүй бөгөөд хоригдогсодтой ажиллаж, хүнд хэлбэрийн мэдээлэл тогтмол авдаг ч сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагддаггүй, хоригдолтой харилцах стандарт журмыг нарийвчлан тодорхойлоогүй, хаалттай хорих ангитай ижилхэн байхаар хуульчилсан нь алба хаагчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, тусгай нэгжид хорих ял эдэлж байгаа хоригдлыг халуун усанд оруулахад гав, тусгай хэрэгсэл хэрэглэх эсэх, харуул хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах гэх мэт хөдөлмөр зохион байгуулалтын бусад асуудлыг нарийвчлан журамлах.

Мөн 2021 онд Улсын Их Хурлаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар төв, суурин газраас алслагдсан хорих ангид ажилласан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишиг, нэмэгдлийн хэмжээг тогтоосон зохицуулалтад зарим алба хаагчид хамрагдахгүй байх нөхцөл үүсэж байгааг нэг мөр шийдвэрлэх талаар цөөнгүй алба хаагч саналаа илэрхийлж байсныг анхаарч шийдвэрлэх нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад "... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах... эрхтэй", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 288 дугаар зүйлийн 288.1 дэх хэсэгт "Аймгийн төвөөс бусад суманд томилогдсон алба хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ..." гэж тус тус заажээ.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийг үндэслэн дараах Зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын барилга, түүний харьяа Ерөнхий боловсролын 110 дугаар сургуулийн барилга, 435 дугаар хаалттай хорих ангийн болон Баян-Өлгий аймаг дахь Цагдан хорих байрыг шинээр барих асуудлыг нэн даруй шийдвэрлүүлэх, бусад хорих ангийн ахуй нөхцөлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн

231 дүгээр зүйлийн 231.1 дэх хэсэгт заасан “Хоригдлыг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан байр, ахуйн нөхцөл, ... хангана” гэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2.405 дугаар хаалттай хорих анги (тусгай нэгж), 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн гадна хамгаалалтын 4 метрийн өндөртэй цементэн блокон хашаа, 2 метрийн өндөртэй торон саад барих асуудлыг шийдвэрлэх.

3. Алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлага, харилцаа хандлагыг дээшлүүлэх, хүний эрхийн ойлголт, хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий харьцаж, нэр төрийг нь гутаан доромжилж шийтгэхгүй байх талаарх сургалтыг нийт алба хаагчдын дунд тогтмол хугацаанд бодит үр дүнд хүрэхүйц байдлаар зохион байгуулж хэвших;

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 228 дугаар зүйлд заасан хоригдлыг сахилгын байранд хорих шийтгэлийг аль болох хэрэглэхгүй байх, уг шийтгэл оногдуулсан тохиолдолд хоригдлын хоолны илчлэгийг бусад хоригдлоос бууруулахгүй байх, тодорхой хугацаанд ном унших, амрах боломжоор хангах зохицуулалтыг холбогдох журам, зааварт тусгах.

5. Тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлэн хорьж байгаа тохиолдлыг тухайн хоригдлын эрх зүйн байдлыг дордуулж байгаа хүний эрхийн ноцтой зөрчил гэдгийг хүлээн зөвшөөрч аль болох хэрэглэхээс татгалзах, зэрэглэл хүндрүүлэх арга хэмжээний оронд сургалт, сэтгэл зүйн үйлчилгээг үр нөлөөтэй зохион явуулах, хоригдол удаа дараа зөрчил гаргасан ч хорих ял шийтгүүлсэн гэмт хэргийн шинж, оногдуулсан ялын хугацааг харгалзаж байх;

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хоригдлыг “сахилгын байранд хорих” шийтгэл оногдуулах, хорих байгууллагын саналыг үндэслэн прокурорын дүгнэлтээр “хорих ялын зэрэглэл хүндрүүлэх” шийдвэрийг зөвхөн шүүх шийдвэрлэдэг байх эрх зүйн зохицуулалтыг судалж, холбогдох санал дүгнэлтийг эрх бүхий байгууллагад уламжлах;

7. Хоригдлын эцгийн нэрийг шаардлагагүй тохиолдолд олон удаагийн давтамжтайгаар дуудахгүй байх, хүний эцэг (эх)-ийн нэр, ял эдэлж байгаа болон эдэлсэн эсэх, үйлдсэн гэмт хэргийн талаарх мэдээлэл нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан “Хүний хувийн мэдээлэл”, “Хүний эмзэг мэдээлэл”-д хамаарах тул хоригдлын хувийн нууцыг хамгаалах, ийм үйлдлийг бүх хорих ангиудад нэн даруй хориглох;

8. Хорих байрны өрөөнд байрлах бие засах зориулалттай ариун цэврийн хэсэгт хаалт суурилуулж, хүний хувийн нууцтай байх, халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангах арга хэмжээг бүх хорих анги, цагдан хорих байранд зохион байгуулах;

9. Хорих ангийн эмнэлгийн төсөв, эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг түргэн шуурхай ялгаварлалгүй хүргэж, хорих ангид ар гэрийн зүгээс илгээж байгаа эм тарианы бүртгэл хяналтыг сайжруулж, эрүүл ахуйн шаардлагыг хангахад онцгой анхаарах;

10. Хорих ял эдэлж байгаа хорт хавдартай, хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй болон амь нас эрүүл мэндэд нь эрсдэл учирч болзошгүй өвчтэй хүмүүст тавих эмнэлгийн хяналтыг сайжруулах, шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй, тогтмол үзүүлж байх, бичиг баримтгүй, групп тогтоогоогүй, сунгаагүй гэх шалтгаанаар нэг ч хүнийг эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн халамжаас гадуур үлдээхгүй байх шаардлагатай бүх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;

11. Сургалтын жишиг хөтөлбөрт тусгагдсан хичээлийн сэдэв бүрээр жишиг гарын авлага, удирдамж боловсруулах, сургалт, нийгэм, сэтгэл зүйн ажил зохион явуулах алба хаагчдыг чадавхжуулах, сургалтын арга зүй эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, үр дүнг тооцож хэвших;

12. “Хоригдлыг суллахад бэлдэх хөтөлбөр”-т нийт хоригдлыг ямар нэгэн шалгуур тавилгүйгээр жигд хамруулах;

13. Бичиг үсэг үл мэдэгч хоригдолд бичиг үсгийн боловсрол олгох сургалтын чанарыг сайжруулах;

14.Зарим ангийн Нийгэм, сэтгэл зүйн нэгжид шаардлагатай орон тоог нэмэх, сул орон тооны нөхөн хангалтыг хийх;

15.Хорих ангийн сургалт, нийгэмшүүлэх ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх;

16.Удаан хугацааны уулзалтыг зохион байгуулах байрны орчин нөхцөлийг сайжруулах, хоригдлоос гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, хариу мэдэгдэх үйл ажиллагааг сайжруулах;


14.Албан хаагчдын хөдөлмөрийн аятай нөхцөлийг хангах, цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж байх;

15.Бие дааж хөрөнгө төвлөрүүлэх боломжгүй хорих ангийн ахуй нөхцөл, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах талаар бодитой арга хэмжээ авч хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

16.Хорих 405 дугаар хаалттай (тусгай нэгж) ангид ажиллах албан хаагчдын хөдөлмөрийн зохион байгуулалтыг нарийвчлан журамлах.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дүнг нотлох баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

ГИШҮҮН



Б.ЭНХБОЛД